



ЭМГЭГ СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН

*Э.Баярмаа*  
Э.БАЯРМАА

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2020 оны 08 сарын 11 ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт

### БИО-АНАГААХЫН МЭРГЭЖИЛТЭН – ЭС СУДЛААЧ

**АХЛАХ** зэрэг горилогч био-анагаахын мэргэжилтэн/ эс судлаач нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг холбоо/мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд хамрагдсан байна (сертификатаар баталгаажуулна).
2. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож 5 өөс цөөнгүй бүтээлийг нийтлүүлсэн байна.(Өөрөө болон бусад эмч нартай хамтран оношилсон ховор тохиолдол - 2, ЭШ-ний илтгэл -2) тус бүр мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна.
3. Эмэгтэйчүүдийн болон эмэгтэйчүүдийн бус эсийн шинжилгээг харж дүгнэх чадвартай байх.
4. Эсийн шинжилгээний гадаад болон дотоод хяналтыг хийх чадвартай байх.
5. Эс судлалын оношлоход төвөгтэй тохиолдлыг дотоод, гадаадын эх сурвалжаас олж мэдэх, оношлох, дүгнэх мэдлэг чадвартай байх.
6. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичгээр өгөх.

**ТЭРГҮҮЛЭХ** зэрэг горилогч био-анагаахын мэргэжилтэн/ эс судлаач нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .Үүнд

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/мэргэжлийн чиглэлийн сургалтанд хамрагдсан байна.
2. Эрдэм шинжилгээ судалгааны ажил гардан хийж сүүлийн 5 жилд 7 оос цөөнгүй бүтээлийг нийтлүүлсэн байна.(Өөрөө болон бусад эмч нартай хамтран оношилсон ховор тохиолдол-2 оос дээш, ЭШ-ний илтгэл -3, нэгдүгээр зохиогчоор судалгааны өгүүлэл-1) тус бүрийн хураангуйг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна.

3. Эс судлаач болон ахлах зэрэгтэй эс судлаач нарт зөвөлгөө өгөх, мэргэжил, арга зүйгээр хангах чадвар эзэмшсэн байх
4. Эс судлалын шинжлэх ухааны оношлогооны шинэ арга, технологиос суралцаж, (ИГХ ийн будаг /биомаркерийн/ үр дүнг үнэлэх чадвар эзэмшсэн бол давуу тал болно)
5. Ахлах зэрэг хамгаалснаас хойш мэргэжлээрээ тасралтгүй 5 жил ажилласан байх
6. Төгсөлтийн дараах сургалтанд тойролт удирдагч багшаар ажиллаж, эс судлаач, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, дагалдан сургасан байх.
7. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан
8. Магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно.